

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРОО
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
Д.БАУЫРЖАН ТАНАА

2022 оны 05 дугаар сарын 27-ны өдөр

№

Өлгий хот

Зөвлөмж хүргүүлэх тухай


“Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжигдэх “Сум дундын ойн ангид нийлүүлэх трактор, усны цахилгаан насос, 1 га талбайн бороожуулагчийг нийлүүлэх ажил БӨАОНӨГ/202205090”-ны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хорооны дүгнэлтийг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 47.2.2 дахь заалтын дагуу хавсралтаар хүргүүлж байна.

Үнэлгээний хорооны дүгнэлтээр тус тендерт үнийн санал ирүүлсэн “ПГЖМ” ХХК тендерийн баримт бичиг шаардлага хангасан тул хуулийн 46.1.3 дахь заалтын дагуу “ПГЖМ” ХХК-тай **57 500 000 /тавин долоон сая таван зуун мянган /** төгрөгийн санхүүжигдэх гэрээг байгуулахыг зөвлөмж болгож байна.

Үнэлгээний хорооны дүгнэлт, холбогдох материалыг хавсаргав.

Хянасан:

ОНӨГ-ын дарга



Т.Назым

Зөвлөмж хүргүүлсэн:

Үнэлгээний хорооны дарга



Б.Жанибек


Үнэлгээний хорооны гишүүн



М.Толхын

Тэмдэглэл хөтөлсөн үнэлгээний хорооны

нарийн бичгийн дарга



А.Багдад

Сум дундын ойн ангид нийлүүлэх трактор, усны цахилгаан насос, 1 га талбайн бороожуулагчийг нийлүүлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах хурлын тэмдэглэл

2022 оны 05 дугаар сар 26

№

Өлгий сум

Хурал 2022 оны 05 дугаар сар 26-ны өдөр ЗДТГ-ын байр 2 дугаар давхарт үнэлгээний хурлын заалд 16 цаг 00 минутанд эхлэв. Хуралд Үнэлгээний хорооны дарга Б.Жанибек, гишүүд М.Толхын үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга А.Багдад нар оролцов.

Хэлэлцэх асуудал: Сум дундын ойн ангид нийлүүлэх трактор, усны цахилгаан насос, 1 га талбайн бороожуулагчийг нийлүүлэх ажлын тендерт үнийн санал ирүүлсэн компаниудын тендерийн баримт бичгийг үнэлж гүйцэтгэгч компанийг сонгон шалгаруулах.

А.Багдад: Сум дундын ойн ангид нийлүүлэх трактор, усны цахилгаан насос, 1 га талбайн бороожуулагчийг нийлүүлэх ажлыг цахим системээр олон нийтэд зарлан мэдээллэсэн.

Үүнд: Үндэсний хэмжээний цахим вэб сайт болох www.tender.gov.mn-д зарласан байгаа.

Хүлээж авах хугацаа 2022 оны 05 дугаар сарын 13 өдрийн 10 цаг 00 минут хүртэл тендерийн баримт бичгийг цахимаар хүлээж авсан. Цахим тендерийн нээлтийг "ПГЖМ" ХХКомпани үнийн саналаа ирүүлсэн. /Нээлтийн тэмдэглэлийг хавсаргав./

Компаний ирүүлсэн үнийн саналыг мөн өдрийн 10 цаг 30 минутанд нээж, нээлтийн тэмдэглэлийг маягтын дагуу үйлдэв.Нээлтэнд үнэлгээний хорооны гишүүд оролцов.

Үүнд: "ПГЖМ" ХХК 57 500 000 төгрөгийн үнийн санал ирүүлсэн байна.

Б.Жанибек: Сум дундын ойн ангид нийлүүлэх трактор, усны цахилгаан насос, 1 га талбайн бороожуулагчийг нийлүүлэх ажлын тендерт ганцхан ПГЖМ ХХКомпани үнийн санал ирүүлсэн байна. "ПГЖМ" ХХКомпаний хувьд нийлүүлэх бараа нь захиалагч байгууллагын техникийн тодорхойлолтын дагуу нийлүүлэхээр санал болгосон байна. Ганцхан компани байгаа учир шалгаруулья гэсэн саналтай байна.

М.Толхын: Сум дундын ойн ангид нийлүүлэх трактор, усны цахилгаан насос, 1 га талбайн бороожуулагчийг нийлүүлэх ажлын тендерт үнийн санал ирүүлсэн ПГЖМ ХХКомпанийг шалгаруулахыг дэмжиж байна. Учир нь Ганцхан компани байгаа байна. Шаардсан борлуулалт, санхүүгийн тайлан шаардлага хангаж байгаа байна. Татварт өргүй байна. Иймд "ПГЖМ" ХХКомпанийг шалгаруулья гэсэн саналтай байна.

А.Багдад: Сум дундын ойн ангид нийлүүлэх трактор, усны цахилгаан насос, 1 га талбайн бороожуулагчийг нийлүүлэх ажлын тендерт ганц ПГЖМ ХХКомпани үнийн

санал ирүүлсэн байна. Энэ тендерт өөр оролцогч байхгүй байна. ТББ-д шаардлагуудыг хангаж байгаа нийлүүлэх трактор, усны цахилгаан насос, талбайн бороожуулагчийг захиалагч байгууллагын техникийн тодорхойлолтын дагуу нийлүүлэхээр санал болгосон байна. Иймээс ПГЖМ ХХКомпанийг шалгаруулья гэсэн гишүүдийн саналтай санал нэг байна.

Үнэлгээний хорооны дүгнэлт:

Үнэлгээний хорооны гишүүдийн олонхийн саналаар тендерийн баримт бичгийн шаардлага хангасан тендер ирүүлсэн "ПГЖМ" ХХКомпаний тендерийн баримт бичгийг шалгаруулав. Иймд "ПГЖМ" ХХКомпанитай хуулийн 46.1.3 дахь заалтын дагуу 57 500 000 /Тавин долоон сая таван зуун мянган / төгрөгөөр санхүүжигдэх гэрээ байгуулахыг зөвлөмж болгож байна.

Үнэлгээний хорооны дарга



Б.Жанибек

Үнэлгээний хорооны гишүүн



М.Толхын

Тэмдэглэл хөтөлсөн үнэлгээний хорооны

нарийн бичгийн дарга



А.Багдад



**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 01/2022

Өлгий

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.3, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалт, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.2, 17.2.9, Усны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3, Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.2, Аялал жуулчлалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдтай 2022 онд хамтран ажиллах гэрээний биелэлтийг хангах ажлын хүрээнд байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах 2000000 /хоёр сая/, 5 /тав/ байгаль хамгаалагчдыг мотоциклээр хангах 12500000 /арван хоёр сая таван зуун мянга/, нөхөрлөлүүдэд дэмжлэг үзүүлэх чадавхжуулах сургалт зохион байгуулах 3000000 /гурван сая/, байгууллагын веб сайт, цахим мэдээллийг шинэчлэх 500000 /таван зуун мянга, биотехникийн арга хэмжээ 8000000 /найман сая/, Алтанцөгц, Баяннуур, Ногооннуур сумдад тус бүр 1 /нэг/ булаг шандны эхийг хамгаалж, орчныг тохижуулах 9000000 /есөн сая/, Чигэртэй голын байгалийн цогцолборт газарт биотехникийн арга хэмжээ авах 2000000 /хоёр сая/, Монгол Алтайн нурууны тусгай хамгаалалттай газарт ойжуулалт хийх 3000000 /гурван сая/, гоёл чимэглэл, жимсний модны тарьц суулгацаар хангах 15000000 /арван таван сая/, Алтай Таванбогдын байгалийн цогцолборт газрын төлөвлөсөн маршрутын дагуу отоглох цэг байгуулах 12000000 /арван хоёр сая/, нийт 67000000 /жаран долоон сая/ төгрөгийг Байгаль хамгаалах сангаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /Т.Фестиваль/-т зөвшөөрсүгэй.

2. Дээрх санхүүжилтийг зориулалтын дагуу зүй зохистой зарцуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар /Ш.Марат/-т болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс /Х Анар/-т даалгасугай

ЗАСАГ ДАРГА



Д.БАУЫРЖАН



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 08 сарын 04 өдөр

Дугаар А/БЧ

Өлгий

Хөрөнгө зарцуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, аймгийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн А/267 тоо захирамж, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын аймгийн Засаг даргатай 2022 онд байгуулсан хамтран ажиллах гэрээг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2022 оны төсөвт тусгагдсан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас байгаль хамгаалагчдыг мотоциклээр хангах "ПОРТ МАКС" ХХК-д 12500000 /арван хоёр сая таван зуун мянга/, Сум дундын ойн ангийн мод үржүүлгийн газрын трактор, усны цахилгаан насос, бороожуулагчаар хангах "ПГЖМ" ХХК-д 57500000 /тавин долоон сая таван зуун мянга/ төгрөгийг гэрээний дагуу олгохыг нягтлан бодогч /Х.Тилеухан/-д зөвшөөрсүгэй.
2. Дээрх арга хэмжээний ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг мэргэжилтэн /Х.Даут/, мэргэжилтэн /Б.Хасым/ нарт үүрэг болгосугай.

ДАРГА

Ш. МАРАТ

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ:

БАЯН-ӨЛНИЙ АЙМГИЙН БАЙГАЛЬ
ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГА Ш. МАРАТ

ГҮЙЦЭТГЭГЧ:

“ПГЖМ” ХХК-НИ
ЗАХИРАЛ Х. БАХЫТГҮЛ



*"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд СДОАнгийн
Мод үржүүлгийн газрыг трактор, усны цахилгаан насос,
бороожуулагч нийлүүлэх тухай гэрээ*

2022 оны 8 сарын 04 -ны өдөр

№ Б.а. - 08 / 2022

Өлгий хот

Нэг талаас Баян-Өлгий аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар (цаашид "захиалагч" гэх)-ын дарга Ш. Марат, нөгөө талаас "ПГЖМ" ХХК (цаашид "гүйцэтгэгч" гэх)-ын захирал Х. Бахытгүл нар дараах зүйлийг харилцан тохиролцож энэхүү гэрээг (цаашид "гэрээ" гэх) байгуулав.

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Иргэний тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу мод үржүүлгийн талбайг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2022 онд "Тэрбум мод" аяны хүрээнд Баян-Өлгий аймгийн хэмжээнд СДОАнгийн Мод үржүүлгийн газрыг трактор, усны цахилгаан насос, бороожуулагч нийлүүлэхтэй холбогдуулан захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино

Хоёр. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

2.1 Гүйцэтгэгчээс гэрээт ажлын дагуу доорх хүснэгт байгаа тоног төхөөрөмжийг техникийн шаардлагын дагуу хүлээж авах үүрэгтэй.

№	Тоног, төхөөрөмжийн нэр, төрөл	Хэмжих нэгж	Тоо
1	Трактор	ширхэг	1
2	Усны цахилгаан насос	ширхэг	1
3	Бороожуулагч	ширхэг	1
Дүн		ширхэг	3

2.2 Гүйцэтгэгчийн ажлын явцад үүссэн саад бэрхшээлийн улмаас гэрээт ажил хийгдээгүй буюу дутуу хийгдсэн тохиолдолд олгосон санхүүжилтийг буцаан нэхэмжлэх эрхтэй.

2.3 Ажил гүйцэтгэж байх хугацаанд Байгаль орчин, аялал жуулчлалын газраас төслийн менежер томилон ажлын гүйцэтгэлд хяналт тавина.

2.4 Ажлын нийт санхүүжилт 57.500.000.0 / тавин долоон сая таван зуун мянган / төгрөг бөгөөд захиалагч нь дараах хуваарийн дагуу санхүүжилтийг олгоно.

Эхний санхүүжилт	50%	28.750.000
Сүүлийн санхүүжилт	50%	28.750.000

2.5 Гэрээнд тусгасан ажлын хэрэгжилтийн явцад тус газраас томилогдсон ажлын хэсэг хяналт тавьж гүйцэтгэлийн хэмжээ, үр дүнг тодорхойлон дүгнэлт гаргана. Гүйцэтгэлийн хэмжээ, үр дүнгээр нь санхүүжилтийг 12 сард багтаан хийнэ.

Гурав. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1 "Тэрбум мод" аяны хүрээнд Баян-Өлгий аймгийн хэмжээнд тоног, төхөөрөмжийг техникийн стандарт чанарын шардлага хангасан байна.

3.2 Ажлын гүйцэтгэлийн эцсийн мэдээ, баримт материалыг 12 сарын 15-ны дотор захиалагчид хүргүүлэх үүрэгтэй.

3.3 Гүйцэтгэгч ажлын чанарт сөргөөр нөлөөлөх эсхүл хугацаа хоцроож болзошгүй нөхцөл байдлын талаар Байгаль орчин, аялал жуулчлалын газарт аль болох урьдаас урьдчилан анхааруулах үүрэгтэй.

3.4 Гүйцэтгэгч нь захиалагч, гүйцэтгэгч нарын хооронд байгуулсан гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.

3.5 Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Дөрөв. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

4.1. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

4.2. Гэрээний аль нэг тал үүргээ зөрчсөн тохиолдолд Иргэний хуулийн 225, 226 дугаар зүйлүүдэд заасан үндэслэл, журмын дагуу нөгөө тал гэрээг цуцалж, учирсан хохирлоо нөхөн төлүүлэхээр шаардах эрхтэй.

4.3. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих шатны Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргана.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Баян-Өлгий аймгийн Байгаль орчин аялал
жуулчлалын газрын мэргэжилтэн

Б. ХАСЫМ

Хаяг: Баян-Өлгий аймаг Өлгий сум 5-р баг
БОАЖГазар
Утас: 99423066, 94509901
Харилцагч банкны нэр: Төрийн сан
Дансны дугаар: 100020013401
Регистрийн дугаар: 9006974



ТӨЛӨӨЛЖ:

“ПГЖМ” ХХК-ний захирал

Х. БАХЫТГҮҮЛ

Хаяг: Баян-Өлгий аймаг Өлгий сум 5-р
баг
Утас: 99429005
Харилцагч банкны нэр: Капитрон банк
Дансны дугаар: 3005029448
Регистрийн дугаар: 3062996

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ:

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН БАЙГАЛЬ
ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГА Ш. МАРАТ



**"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд СДОАнгийн
Мод үржүүлгийн газрыг трактор, усны цахилгаан насос,
бороожуулагч нийлүүлэх тухай гэрээ**

ГҮЙЦЭТГЭГЧ:

"ПГЖМ" ХХК-ИЙ
ЗАХИРАЛ Х. БАХЫТГҮЛ



2022 оны 12 сарын 22-ны өдөр

№ 02

Өлгий хот

Нэг талаас Баян-Өлгий аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар (цаашид "захиалагч" гэх)-ын дарга Ш. Марат, нөгөө талаас "ПГЖМ" ХХК (цаашид "гүйцэтгэгч" гэх)-ын захирал Х. Бахытгүл нар дараах зүйлийг харилцан тохиролцож 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдөр энэхүү НЭМЭЛТ ГЭРЭЭГ (цаашид "гэрээ" гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Гэрээний талууд гэрээгээр хүлээсэн эрх үүргээ хэрэгжүүлэхэд авлига, ашиг сонирхлоос ангид байх зарчмыг баримтална.
3. Нийлүүлэгч нь техникийн тодорхойлолтод заасан үзүүлэлт, шаардлагын дагуу тоног төхөөрөмжийг 2022 оны 12 дугаар сарын 15 –ны өдөр хүртэл нийлүүлэх байсан боловч Хятад улсаас орж ирэх байсан техник хэрэгсэл цар тахал, хил гаалийн улмаас хойшлогдсон тул 2023 оны 03 дугаар сарын 20-ны дотор нийлүүлж дуусгахаар БОХ-08/2022 гэрээний хугацааг сунгав.
4. Гэрээний бусад нөхцөл БОХ-08/2022 дугаар гэрээнд заагдсанаар хэвээр хадгалагдана.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Баян-Өлгий аймгийн Байгаль орчин
аялал жуулчлалын газрын мэргэжилтэн

Б. ХАСЫМ

Хаяг: Баян-Өлгий аймаг Өлгий сум 5-р
баг БОАЖГазар
Утас: 99423066, 94509901

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

"ПГЖМ" ХХК-ний захирал



Х. БАХЫТГҮЛ

Хаяг: Баян-Өлгий аймаг Өлгий сум
5-р баг

Утас: 99429005

Харилцагч банкны нэр: Капитрон
банк

Дансны дугаар: 3005029448

Регистрийн дугаар: 3062996

Гэрээ гүйцэтгэсэн